



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ

# ЖИЛИЙН ТАЙЛАН

# 2021



## ГАРЧИГ

<b>1</b>	<b>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ</b>	x4
<b>2</b>	<b>БИДНИЙ ТУХАЙ</b>	x6
	Түүхэн товчоон	x8
<b>3</b>	<b>БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>	x10
	Газруудын чиг үүрэг	x10
	Удирдлагын баг	x11
	Хүний нөөц	x12
<b>4</b>	<b>САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	x13
<b>5</b>	<b>КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ</b>	x14
	Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэл	x14
	“МХБ” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 онд ажилласан бүрэлдэхүүн	x15



<b>6</b>	<b>ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД</b>	x16
	<b>Шинэ бүтээгдэхүүн</b>	x20
	Бонд	x20
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	x21
	Компанийн хувьцаа	x22
	Хөрөнгө оруулалтын сан	x23
<b>7</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ</b>	x25
<b>8</b>	<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>	x32
	Аудитын дүгнэлт	x33
	СТ4 тайлан /Аудитлагдсан/	x35

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсэж хөгжсөний 30 жилийн ойг буухиалсан 2021 онд Монголын хөрөнгийн биржийн голлох үзүүлэлтүүд түүхэн дээд хэмжээндээ хүрээд зогсохгүй салбарын хөгжлийг шинэ шатанд түүчээлэх онцлох үйл явдлуудаар өрнүүн жил байлаа.

Монгол Улс одоогоос 31 жилийн өмнө улс, нийгмийн өмчид тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж, хөрөнгийн зах зээлийн үндсэн дэд бүтцийн байгууллага болох Монголын хөрөнгийн биржийг 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр байгуулж байсан. Улмаар монголчууд бид цэнхэр, ягаан тасалбараар “хөрөнгийг зах зээл” хэмээх шинэ, соргог ертөнцөд хөл тавьснаас хойш эдүгээ тоолж барамгүй олон ахиц дэвшил гарчээ. Энэхүү түүхэн хугацаанд Монголын хөрөнгийн зах зээл олон улсын жишгээр өргөжин тэлж, хууль эрхзүйн орчин, техник технологийн хувьд хөгжлийн шинэ түвшинд хүрээд байна.

Хэдийгээр 2021 онд дэлхий нийтийг хамраад буй цар тахлын сүүдэрт Монгол Улсын эдийн засаг агшиж, хүнд бэрх сорилтуудтай нүүр тулсан ч Монголын хөрөнгийн зах зээл онцгой өсөлттэй байлаа. Тухайлбал, 2021 оны жилийн эцэст хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 95.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс 2021 оны эцсийн байдлаар 44 мянган нэгжийн түвшнийг давж, 133 хувиар өссөн нь дэлхийн томоохон индексүүдтэй харьцуулахад дунджаар тав дахин өндөр үзүүлэлт байлаа. Үүнд дотоодын хөрөнгө оруулагчид идэвхжиж, иргэдийн хөрөнгө оруулах хандлагад томоохон өөрчлөлт гарсан нь ихээхэн нөлөө үзүүлсэн бөгөөд энэ хэрээр Монголын хөрөнгийн биржийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдлээ.

Тухайлбал, Сэнтрал Экспресс Си Ви Эс компани Монголын хөрөнгийн биржийн түүхэнд хамгийн өндөр дүнтэй IPO хийж, 28.7 тэрбум төгрөг татан



Гүйцэтгэх захирал  
**Х.АЛТАЙ**

**“КОМПАНИЙН  
САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН БОЛОН  
ҮР АШГИЙН  
ҮЗҮҮЛЭЛТҮҮД  
САЙЖИРСНААР  
МХБ 2021 ОНД 5.5  
ТЭРБУМ ТӨГРӨГИЙН  
ОРЛОГО ОЛЖ, 2.1  
ТЭРБУМ ТӨГРӨГИЙН  
ХУРИМТЛАГДСАН  
ӨР ТӨЛБӨРИЙГ  
БАРАГДУУЛААД  
БАЙНА.”**

төвлөрүүлсэн бол банкны салбарын IPO-г Богд банк амжилттай эхлүүлж, банкны нэр арилжааны самбарт бичигдэх түүхэн чухал үйл явдлын шанг татлаа. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК бонд гаргасан нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Мөн хамтын хөрөнгө оруулалтын сангууд шинээр байгуулагдаж, нийт 55 тэрбум төгрөг олон нийтээс татан төвлөрүүлж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг тавьсан нь онцлох үйл явдлын нэгд зүй ёсоор багтана.

2021 онд Монголын хөрөнгийн зах зээлд өрнөсөн бас нэгэн томоохон үйл явдал бол Монголын хөрөнгийн биржийн цойлсон өсөлтийг дэлхийн тэргүүлэх санхүүгийн судалгааны агентлаг болох Их Британийн “FTSE Russell” группээс анхаарч, Монголын хөрөнгийн зах зээлийг “Хөгжиж буй зах зээл”-ийн “Ажиглалтын жагсаалт”-д оруулсан явдал юм. Ингэснээр олон улсын санхүүгийн зах зээлийн томоохон хөрөнгө оруулагч, оролцогчдыг Монгол Улсын хөрөнгийн

зах зээлрүү татах суурь нөхцөл бүрдлээ.

Компанийн санхүү, эдийн засгийн болон үр ашгийн үзүүлэлтүүд сайжирснаар МХБ 2021 онд 5.5 тэрбум төгрөгийн орлого олж, 2.1 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулаад байна. Улсын төсөвт 530.8 сая төгрөгийн татвар, хураамжийг зохих хуулийн хугацаанд нь бүрэн төлж, татварын дараах цэвэр ашгийг 3.2 тэрбум төгрөгт хүргэж ажилласан нь компанийн 30 жилийн түүхэн дэх онцлох өндөр үзүүлэлт боллоо.

Цаашид Монголын хөрөнгийн бирж улс орныхоо эдийн засгийн хөгжлийн гол тулгуур болж, хөгжлийн түүчээ болох эрхэм зорилгынхоо төлөө хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, үнэт цаас гаргагч болон дотоод, гадаадын хөрөнгө оруулагч та бүхэнтэй бүхий л талаар хамтран ажиллахад таатай байх болно.

Хөрөнгийн зах зээлийн оролцогчид, мэргэжлийн байгууллагууд, үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчид та бүхэндээ Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны түүхт 30 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлье!


## БИДНИЙ ТУХАЙ

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн тvvхэн вeд Монгол Улсын Засгийн газрын 1991 оны нэгдүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлж, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулсан.


Улмаар 1992 онд Засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд 475 улсын үйлдвэрийн газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, тэдгээрийн 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр эзэмшүүлсний дүнд нийт хүн амын 52 орчим хувь буюу 1.2 сая хүн хувьцаа эзэмшигч болж байсан түүхтэй.

Ингэснээр Монгол Улсын эдийн засгийн бүтцийг өөрчилж, үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, эдийн засагт хувийн секторыг дэмжин хөгжүүлэх, өмч хувьчлалыг өргөн хүрээнд зохион байгуулах суурь нөхцөл бүрдсэн юм.

Мөн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Монголын хөрөнгийн бирж нь олон улсад нэр хүнд бүхий “Лондонгийн хөрөнгийн бирж” групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник технологи, дэд бүтцийн хувьд хөгжлийн шинэ түвшинд хүрээд байна. Үүгээр зогсохгүй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 оноос хойш үе шаттай шинэчилсний үр дүнд хууль эрхзүйн орчин ч олон улсын жишигт хүрч хөгжжээ.



1991 он



2021 он

**Хууль эрхзүйн таатай орчин бий болсноор гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд дотоодын хөрөнгийн биржид үнэт цаасны давхар бүртгэл хийлгэх боломж бүрдэж, 2018 онд Монголын хөрөнгийн бирж дээр анхны давхар бүртгэл хийгдсэн. Үүнээс гадна хадгаламжийн бичиг, төлбөр тооцооны дараа төлбөрт систем, үнэт цаасны номинал болон бенефициар өмчлөл, кастодиан зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээ хөрөнгийн зах зээлд шинээр нэвтрээд байна.**

Мөн 2020 онд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг цоо шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт T+2 горимыг амжилттай нэвтрүүлсэн.

Монголын хөрөнгийн бирж нь 1995 оны наймдугаар сарын 28-ны өдөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлснээс хойш 2021 оны эцсийн байдлаар нийт 4.75 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжааг зохион байгуулж, 30 жилийнхээ ойг түүхэн дээд амжилт, голлох үзүүлэлтүүдийн онцгой өсөлтөөр үдэж байна.

Түүнчлэн 2021 оны эхэнд Банкны тухай хуулийг шинэчлэн баталж, системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих томоохон шинэтгэлийн ажил гараанаасаа хөдөлсөн нь ирэх жилүүдэд хөрөнгийн зах зээл улам өргөжин тэлэх үндэс суурийг тавилаа. 2021 оны арванхоёрдугаар сард Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 5.97 их наяд төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 13.7 хувьтай тэнцэж байна. Цаашид томоохон банкууд IPO хийснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 30 гаруй хувьтай тэнцэж, хоёр дахин тэлэх төлөвтэй байна.

2021 оны бас нэгэн онцлох үйл явдал нь Монголын хөрөнгийн бирж гадаадын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, зах зээлд олон улсын

стандартууд нэвтрүүлэх зорилгоор, дэлхийн ТОП-5 хөрөнгийн биржийн нэг болох Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагаа эхлүүлсэн явдал байлаа.

Монголын хөрөнгийн зах зээл дэх эдгээр таатай уур амьсгал болон онцлох өсөлтүүдийг Их Британийн "FTSE Russell" группээс онцгойлон үзэж, Монголын хөрөнгийн зах зээлийг "Хөгжиж буй зах зээл"-ийн "Ажиглалтын жагсаалт"-д оруулсан нь Монголын хөрөнгийн бирж төдийгүй Монголын хөрөнгийн зах зээлийн ирээдүйг гэрэлтүүлсэн чухал үйл явдал боллоо.

	2020	2021
<b>ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ</b>	₮3.02 их наяд	₮5.97 их наяд
<b>ТОП-20 ИНДЕКС</b>	19,285.80	44,411.60
<b>БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИЙН ТОО</b>	192	179
<b>ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА</b>	₮263 сая	₮5.7 тэрбум

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

1991.01.18

Монголын Хөрөнгийн Бирж байгуулагдав.

1992.02.07

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа эхлэв.

1994.09.26

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдав.

2011.04.07

Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түншлэлийн "Ажлын мастер гэрээ" байгуулав.

2005.05.25

Анхны IPO амжилттай хийгдэв.

2001.06.08

Анхны компанийн бондыг арилжаалав.

2012.06.08

Олон улсад нэр хүнд бүхий "Миллениум Ай Ти" цогц системийг зах зээлд нэвтрүүлээ.

2014.12.02

Монголын хөрөнгийн бирж өөрийгөө зохицуулах байгууллага боллоо.

2015.12.22

Төрийн өмчийн хувьчлалыг хөрөнгийн биржээр нээлттэй явуулав.

2021.01.15

Давхар бүртгэлтэй үнэт цаасны бирж хоорондын хөрвүүлэлт амжилттай хийгдлээ.

2021.01.15

Монголын хөрөнгийн бирж ханшийн лавлагааны үйлчилгээг цахимжууллаа.

2021.01.18

Монголын хөрөнгийн бирж хөрөнгийн зах зээлийн түүхэн үзвэрийн танхимтай боллоо.

2021.06.30

Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагаа эхлүүлээ

2021.09.30

Монголын хөрөнгийн зах зээл FTSE RUSSELL-ийн "хөгжиж буй зах зээлийн ажиглалтын жагсаалт"-нд албан ёсоор орлоо



**1994.11.14**

Үнэт Цаасны Хороо байгуулагдав.

**1995.07.08**

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо байгуулагдав.

**1995.08.28**

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэв.

**2001.02.09**

TOP-20 индекс тооцож эхлэв.

**1996.10.25**

Засгийн газрын бондыг хөрөнгийн биржээр арилжаалж эхлэв.

**1995.08.28**

TOP-75 индекс тооцож эхлэв.

**2017**

859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийж, түүхэн амжилт тогтоов.

**2018.02.08**

MSE A болон MSE B индексүүдийг тооцож эхлэв.

**2018.04.04**

Анхны гадаадын үнэт цаасыг давхар бүртгэв.

**2020.12.28**

Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэв.


**2020.08.24**

Анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан бүртгэгдэв.

**2020.03.31**

Төлбөр тооцооны T+2 горимд шилжив.

# БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ГАЗРУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

**Захиргаа, санхүүгийн газар** нь компанийн дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж ажиллах ба чиг үүргээрээ Захиргааны алба, Санхүүгийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

**Үйл ажиллагааны газар** нь арилжааны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах, хөрөнгийн биржийн мэдээллийн технологийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих үндсэн чиг үүрэгтэйгээр Зах зээлийн хөгжлийн алба, Арилжааны алба, Мэдээллийн технологийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

**Хяналт, зохицуулалтын газар** нь бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаас гаргагч байгууллагууд, гишүүн үнэт цаасны компани, арилжааны хяналт, хөрөнгийн зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх чиг үүрэгтэйгээр Хяналт шинжилгээний алба, Бүртгэлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

## УДИРДЛАГЫН БАГ

---



### **Х.АЛТАЙ**

Гүйцэтгэх захирал

- Хуульч
- Бизнесийн удирдлагын магистр



### **Т.ХАШ-ЭРДЭНЭ**

Дэд захирал

Эдийн засагч



### **Н.ДӨЛ-ЭРДЭНЭ**

Захиргаа, санхүүгийн газрын захирал

- Санхүүч, эдийн засагч
- Бизнесийн удирдлагын магистр
- Олон улсын бизнесийн удирдлагын докторант



### **А.МӨНХБАЯСГАЛАН**

Хяналт, зохицуулалтын газрын захирал

- Эдийн засагч
- Төрийн удирдлагын магистр



### **И.ЖАВХЛАН**

Үйл ажиллагааны газрын захирал

- Санхүүч
- Санхүүгийн удирдлагын магистр

## ХҮНИЙ НӨӨЦ

МХБ-ийн "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав.

Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2021 оны эцэст нийт 53 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба урт хугацааны чөлөөтэй 8 ажилтан байна.



53

Нийт ажилтан



23

Нийт эрэгтэй ажилтан



30

Нийт эмэгтэй ажилтан



28

Үндсэн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн




18

Захиргаа, санхүү, аж ахуйн ажилтан



39

Дундаж нас



8 жил

Ажилласан дундаж хугацаа



9

Удаагийн сургалт



48

Дээд боловсрол

1


Доктарант

17

Магистр

30

Бакалавр



МОНГОЛЫН МЭРГЭШСЭН  
НЯГТЛАН БОДОГЧДЫН  
ИНСТИТУТ

2

Мэргэшсэн  
нягтлан бодогч




CFA Institute

1

Олон улсын  
итгэмжлэгдсэн  
санхүүгийн шинжээч

3

Олон улсын  
итгэмжлэгдсэн  
санхүүгийн шинжээч  
цол горилогч




CISCO  
CERTIFIED  
CCNA

1


Олон улсын мэргэшсэн  
компьютерийн сүлжээний  
инженер

# САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


**НИЙТ ОРЛОГО /сая төгрөг/**




**НИЙТ ЗАРДАЛ /сая төгрөг/**




**МІТ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР /сая төгрөг/**




**АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ /сая төгрөг/**



**ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР, ШИМТГЭЛ  
/сая төгрөг/**



**ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР АШИГ  
/сая төгрөг/**



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 152 дугаар тогтоолоор “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэгчээр Сангийн Яамыг томилсон бөгөөд Төлөөлөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Сангийн сайдын тушаалаар томилогддог. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүдийн бүрэлдэхүүнтэй бөгөөд Компанийн тухай хуулийн 75.4 заалтын дагуу хараат бус 3 гишүүнтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны гишүүний танилцуулга, холбогдох баримт материалыг “Авилагтай тэмцэх газарт” /АТГ/-т хүргүүлэн бие даасан байдлыг тодорхойлуулдаг. АТГ нь гишүүд, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллахад бие даасан үйл ажиллагаа явуулахад, бие даасан үйл ажиллагаа явуулахад материаллагаар нөлөөлж болох ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг хянаж шалгадаг.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 2018/04 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг 3 газар, 6 албатай байхаар баталсан бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 5 дугаар сарын 20-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Компанийн 2021 оны үйл ажиллагааны эдийн засгийн зорилтот түвшин”-д нийт ажилтнуудын тоог 55 байхаар заасан нь тайлант хугацааны эцэст 53 буюу 96%-ийн дүүргэлттэй байлаа.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулдаг.

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол урамшуулал олгодог. ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын дагуу тогтоодог бөгөөд гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг.

МХБ-ийн ТУЗ нь тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой байх бөгөөд Хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хариуцсан асуудлуудаар санал, дүгнэлт гаргаж ажилладаг. **Үүнд:**

### Аудитын хороо

- А.Анар /Дарга/
- А.Батпүрэв /Гишүүн /
- С.Энхзориг /Гишүүн /

### Цалин урамшуулалын хороо

- Б.Наранчимэг /Дарга/
- Р.Гандиймаа /Гишүүн /
- А.Анар /Гишүүн /

### Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

- Д.Баянзул /Дарга/
- Р.Гандиймаа /Гишүүн /
- А.Батпүрэв /Гишүүн /

ТУЗ-ийн дэргэдэх Хороодын үйл ажиллагааг Компанийн тухай хууль болон МХБ-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-аар зохицуулдаг. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш Хороонд ажиллаж болох ба Хороо тус бүрийн 2/3-с доошгүй нь хараат бус гишүүнээс бүрдэхээр заасан байдаг. Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх зохицуулалтыг мөрддөг.

Ийнхүү МХБ-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу 2021 онд 6 хараат, 3 хараат бус гишүүнтэй ажилласан ба тайлант хугацаанд Сангийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 154 дугаар тушаалаар компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. ТУЗ нь 2021 онд нийт 8 удаа хуралдаж холбогдох асуудлуудыг хэлэлцсэнээр нийт 17 тогтоол, 4 тэмдэглэлээр зохих шийдвэрүүдийг гаргаж, Гүйцэтгэх удирдлагад чиглэл, үүрэг даалгавар өгч ажилласан байна.

## “МХБ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНД АЖИЛЛАСАН БҮРЭЛДЭХҮҮН

	НЭР	ҮҮРЭГ	АЛБАН ТУШААЛ	ТОМИЛОГДСОН ОГНОО
1	Б.СҮХ-ОЧИР	ТУЗ-ийн дарга	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын үүргийг түр орлог гүйцэтгэгч	2021.09.10
2	Д.БАЯНЗУЛ	ТУЗ-ийн гишүүн	Монгол банкны эрсдэлийн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2021.09.10
3	Д.ЭНХБААТАР	ТУЗ-ийн гишүүн	Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2021.09.10
4	С.ЭНХЗОРИГ	ТУЗ-ийн гишүүн	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч, улсын ахлах байцаагч	2021.09.10
5	М.САНЖААДОРЖ	ТУЗ-ийн гишүүн	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга;	2021.09.10
6	Б.НАРАНЧИМЭГ	ТУЗ-ийн гишүүн	Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга	2021.09.10
7	А. БАТПҮРЭВ	ТУЗ-ийн гишүүн	“Скайтел” ХХК-ийн Стратегийн удирдлага, төлөвлөлтийн албаны захирал	2021.09.10
8	Р.ГАНДИЙМАА	ТУЗ-ийн гишүүн	“МҮОНРТ”-ийн Монголын мэдээ сувгийн захирал	2021.09.10
9	А.АНАР	ТУЗ-ийн гишүүн	“МИК ОССК” ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал	2021.09.10

# ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

# 2021



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД АЙЛЧИЛЖ, АРИЛЖААГ НЭЭХ ХҮНДЭТГЭЛИЙН ЦАНГ ЦОХИЛОО



Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн арилжааг нээж “Хүндэтгэлийн цан” цохилоо.

Тус ёслолын арга хэмжээнд Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, УИХ-ын гишүүн, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Ерөнхийлөгч Д.Цогтбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай тэргүүтэй зочид, төлөөлөгчид оролцон Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч хөгжсөний 30 жилийн

баярын мэндийг нийт зах зээлд оролцогчид болон үе үеийн ажилтан, албан хаагчдад мэнд дэвшүүлэв. Арга хэмжээний үеэр Ерөнхий сайд У.Хүрэлсүх “30 жилийн туршид хөрөнгийн бирж, хөрөнгийн зах зээл тасралтгүй хөгжин дэвшиж, олон шинэ бүтээгдэхүүнтэй, тогтмол үйл ажиллагаатай, идэвхтэй арилжаатай, хууль эрх зүйн орчны хувьд боловсронгуй болсны зэрэгцээ хөрөнгийн биржийн үйл ажиллагаа, дэд бүтэц, технологийн хувьд олон улсын жишигт хүрч чадсан байна. Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл улам идэвхжиж, хөрөнгө оруулагчид арилжаанд цахимаар оролцох боломж бүрдсэнээс гадна гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасыг Монголдоо давхар арилжих, компаниуд үнэт цаас гаргах буухиа үргэлжилсээр байгааг тэмдэглэн хэлэхэд сайхан байна” хэмээн тодотгон дурдсан юм.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар “Үнэт цаасны зах зээл хурдацтай хөгжиж байна. Эрх зүйн орчин нь боловсронгуй болж, үнэт цаас гаргаж хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр эдийн засаг дахь үүрэг, оролцоо нь улам сайжирч байна. Цаашид технологийн ололт амжилтыг эрчимтэй нэвтрүүлж, хөрөнгийн зах зээлийг хөгжлийг түргэсгэх нь зүйтэй” гэж онцолсон бол УИХ-ын гишүүн, МҮЦАЭХ-ны Ерөнхийлөгч Д.Цогтбаатар Монгол Улсын цаашдын хөгжилд хөрөнгийн зах зээл чухал үүрэгтэй бөгөөд хөрөнгийн зах зээлийн хөгжилд төрийн бодлого дэмжлэг шаардлагатайг тэмдэглэв.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭН ҮЗВЭРИЙН ТАНХИМЫН НЭЭЛТ БОЛЛОО

Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан биржийн үйл ажиллагаатай холбоотой түүхэн үзмэрүүдээр бүрдүүлсэн үзвэрийн танхимыг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нар нээв. Уг музейд хөрөнгийн биржийг үүсгэн байгуулах анхны тогтоол, түүхэн баримт бичгүүдээс эхлээд тухайн үед хэрэглэж байсан компьютер техник хэрэгсэл, бусад хувцас хэрэгсэл, дурсгалын зүйлүүд болон 30 жилийн түүхийг харуулсан түүхэн үзвэрүүдийг багтаасан юм.





## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХАНШИЙН ЛАВЛАГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь өв залгамжлах гэрчилгээгээр үнэт цаас шилжүүлэх хүсэлт гаргасан иргэдэд үнэт цаасны ханшийн лавлагааг гаргаж өгөх үйлчилгээг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс “Гэрэгэ системс” ХХК-ийн Гэрэгэ киоскоор дамжуулан олгож эхлэв.

Гэрэгэ киоск нь татвар, тээвэр, шүүх, харилцаа холбоо, эрүүл мэнд, даатгалтай холбоотой төрийн болон хувийн байгууллагуудын 30 гаруй төрлийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд улсын хэмжээнд 147 байршилд ажиллаж байна.

## ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ ХООРОНДЫН ХӨРВҮҮЛЭЛТ АМЖИЛТТАЙ ХИЙГДЛЭЭ

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга 2013 онд батлагдсанаар үнэт цаасны давхар бүртгэлийг нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдэж, улмаар үнэт цаасны давхар бүртгэлийн ажиллагааг зохицуулах “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 223 тоот тогтоолоор батлав.

Тус журамд 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу МХБ нь “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК-ийн нийт хувьцааг бүртгэж, тус компанийн хувьцаа МХБ болон Торонтогийн хөрөнгийн бирж хооронд хөрвөн арилжаалагдах боломж бүрдсэн ба хөрвүүлгийг 2021 оны 1 дүгээр сард амжилттай зохион байгуулав.



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ FTSE RUSSELL-ИЙН “ХӨГЖИЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛИЙН АЖИГЛАЛТЫН ЖАГСААЛТ”-НД АЛБАН ЁСООР ОРЛОО

Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE Russell группээс 2021 оны 9-р сарын 30-ны өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын жагсаалт”-нд (Watch List) багтаасан тухай мэдээлсэн баярт үйл явдал тохиосон юм. Тус байгууллага нь мэргэжлийн хөрөнгө оруулагчийн зүгээс тавьдаг техникийн хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу олон улсын зах зээлүүдийг “Хөгжиж буй”-гаас “Өндөр хөгжсөн” хүртэл үндсэн 4 зэрэглэлээр ангилдаг. Улс орнуудын хөрөнгийн зах зээлийн зэрэглэлийг жилд нэг удаа тогтоодог бөгөөд аливаа зах зээлийг зэрэглэл дэвшүүлэх, бууруулахын өмнө нэг жилийн хугацаанд “Ажиглалтын жагсаалт”-нд оруулдаг байна.

## ШАНХАЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголын хөрөнгийн бирж нь дотоодын хөрөнгийн зах зээлд оролцох гадаадын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх зорилгоор зах зээлийг сурталчлах, зах зээлд олон улсын стандартууд нэвтрүүлэх, олон улсын зэрэглэлд багтаах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд дэлхийн ТОП-5 хөрөнгийн биржийн нэг болох Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагаа эхлүүлж, “Монголын хөрөнгийн зах зээлийн өдөрлөг” нээлттэй вебинарыг 2021 оны 6 дугаар

сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд Шанхайд төвтэй хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны компаниудын 50 гаруй төлөөлөл оролцсон бол Монголын талаас Монголын хөрөнгийн биржийн төлөөллүүд, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын төлөөллүүд оролцов.

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН СТАНДАРТЫГ МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛНЭ

Монголын хөрөнгийн бирж (МХБ), Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТoС Холбоо), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP), Тогтвортой байдлын санхүүгийн төвүүдийн сүлжээ (FC4S), Олон улсын санхүүгийн корпорацн (OУСК), НҮБ-ын хамтарсан хөтөлбөр тус тус хамтран хэрэгжүүлж буй “Монголын тогтвортой хөрөнгийн биржийн санаачилга” (МТХБС) төслийн хүрээнд “Монголын хөрөнгийн зах зээлд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлагналын стандартыг нэвтрүүлэх “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр байгуулав.



## “ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХОНХ ЦОХИХ” АРГА ХЭМЖЭЭГ ТАВ ДАХЬ УДААГАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь “Жендерийн тэгш байдлын төлөө хонх цохих” ёслолын арга хэмжээг 5 дахь жилдээ уламжлал болгон зохион байгууллаа. Бизнес болон тогтвортой хөгжилд жендерийн тэгш байдлын чухлыг олон нийтэд таниулах зорилготой тус арга хэмжээг олон улсын хөрөнгийн биржүүд Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулдаг билээ. 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулагдсан арга хэмжээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Илэйн Конкиевич, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч ноён Ханнес Такач болон МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүн хатагтай Л.Болормаа нар оролцож жендерийн эрх тэгш байдлын төлөө нэгдэж, Монголын хөрөнгийн биржийн 6,424 дэх арилжааг нээлээ.

## АПУ” ХК НЭГ ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ АНХНЫ КОМПАНИ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны I ангилалд бүртгэлтэй “АПУ” ХК-ийн үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1 их наяд 9 тэрбум төгрөгт хүрснээр МХБ-д бүртгэлтэй компаниудаас 1 их наяд төгрөгийн үнэлгээтэй анхны компани болсонтой холбогдуулан өнөөдөр Монголын хөрөнгийн биржийн 6527 дахь удаагийн арилжааг нээх цан цохих ёслолын арга хэмжээ зохион байгуулагдлаа. Монголын хөрөнгийн биржид 1992 онд бүртгэгдсэн “АПУ” ХК-ийн нэгж үнэт цаас 1995 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр үнэт цаасны хоёрдогч зах зээлд 101 төгрөгөөр арилжигдаж эхэлснээр зах зээлийн үнэлгээ 75 сая төгрөгөөр тооцогдож байсан түүхтэй бөгөөд 26 жилийн дараа ийнхүү нийт 1 их наяд төгрөгийн үнэлгээнд хүрээд байна.



## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

### ДЭД БҮТЦИЙН АНХНЫ БОНД



Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд “Эрдэнэс тавантолгой” ХК нь стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр өөрийн орлогоор баталгаажсан 2 их наяд төгрөг хүртэлх үнийн дүнтэй төгрөг,

### БОНД



ам.долларын бондыг 3 ээлжээр гаргах бөгөөд эхний ээлжийн 600 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй төгрөгийн жилийн 10 хувь, ам долларын 6.8 хувийн хүүтэй бондын анхдагч зах зээлийн захиалгыг бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 02-ны өдрүүдэд авч арилжааг амжилттай зохион байгуулсан. Тус бонд нь 2021 оны байдлаар дотоодын хөрөнгийн зах зээлд гарч буй хамгийн өндөр үнийн дүнтэй үнэт цаас болж байгаа төдийгүй дэд бүтцийн төслийг санхүүжүүлж буй анхны бонд байв.

2021 онд тус бондын 3 трачийн арилжааг зохион байгуулсан бөгөөд үнэт цаасны арилжаанд нийт 1498 иргэн, аж ахуйн нэгж оролцож, 5'957'595 ширхэг үнэт цаасны арилжаалан нийт 692.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

### “ИНВЕСКОР ББСБ” ХК ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН ӨНДӨР ДҮН БҮХИЙ НЭЭЛТТЭЙ ӨРИЙН ХЭРЭГСЭЛ



Монголын Хөрөнгийн Биржийн TOP-20 индекст багтдаг “Инвескор ББСБ” ХК нь хувийн хэвшлийн түүхэн дэх хамгийн өндөр дүн бүхий нээлттэй өрийн хэрэгслийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн Транч 1-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр эхлүүлэв.

“Инвескор Бонд” хөтөлбөрийн хүрээнд нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 200,000 хүртэлх ширхэг үнэт цаасыг зах зээл дээр гаргах замаар 20 тэрбум хүртэлх төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд 2 жилийн хугацаатай, жилийн 12-14 хувийн өгөөжтэй бол хүү төлөх давтамж хагас жилд нэг удаа, хүүгийн орлогын албан татвар 5% байх нөхцөлтэй гаргасан. Үнэт цаасны арилжаанд нийт 155 иргэн, аж ахуйн нэгж оролцож нийт 20 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

## “ЛЭНДМН ББСБ” ХК НЬ ОЛОН НИЙТЭЭС 5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭВ



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн I ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч компани болох “ЛэндМН ББСБ” ХК-ийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй ерийн хэрэгсэл “ЛэндМН Бонд” нь 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 6 дугаар



сарын 30-ны өдөр хүртэл Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэйгээр арилжаалагдаж, нийт 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлэв.

Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд нийт 504 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийт 75,835 ширхэг буюу 7,583,500,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 505 худалдан авах захиалга ирүүлсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 51.6 хувиар давсан дүн юм. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн захиалгын хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 2.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 10 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100 хувь биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгад үнэт цаасыг 31.3 хувиар хувь тэнцүүлэн хуваарилахаар боллоо.

## ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

### “ИНВЕСКОР АКТИВ” ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС



### ИНВЕСКОР АКТИВ

Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох “Инвескор актив ХБҮЦ”-ны анхдагч зах зээлийн арилжааг 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 01 дүгээр сарын 14-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж арилжааны системд А транчийн стратегийн 4 хөрөнгө оруулагчаас 1,700,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 4 захиалга, олон нийт буюу 89 хөрөнгө оруулагчаас 5,686,800,000 төгрөгийн үнийн дүн бүхий 90 захиалга, Б транчийн 3 хөрөнгө оруулагчаас 600,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 3 захиалга, нийт 7,986,800,000 төгрөгийн үнийн дүн бүхий 19,967 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авах захиалга бүртгэгдсэн бөгөөд үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 10 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий захиалгуудыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 22.4 хувиар хувь тэнцүүлэн нийлүүлэлт хийжээ.

## КОМПАНИЙН ХУВЬЦАА

“БОГД БАНК” ХК БИРЖ ДЭЭР НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ  
КОМПАНИ БОЛСОН АНХНЫ БАНК

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэлийн I ангилалд 2021 онд шинээр бүртгэгдсэн анхны арилжааны банк болох “Богд банк” ХК нь нийт хувьцааныхаа 20 хувь буюу 12,500,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс өнөөдөр буюу 12 дугаар сарын 07-ны өдрийн 17:00 цаг хүртэл авч дууслаа.

“Богд банк” ХК-ийн нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд 1,243 хувь хүн, аж ахуйн нэгжээс нийт 33,203,357,520 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 4.6 хувиар давсан үзүүлэлт болж, “Богд банк” ХК нь банкны салбарын реформын хүрээнд хамгийн анхны нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй банк болов.


## ХАМГИЙН ОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ОРОЛЦСОН IPO



Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн байранд зохион байгуулсан.

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн анхдагч зах зээлийн арилжаа таван өдөр амжилттай үргэлжилж, нийт 9643 хөрөнгө оруулагчдаас 28.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд анхдагч зах зээлийн захиалга 61 хувиар давж 40 тэрбум төгрөгийн захиалга авсан нь Монголын хөрөнгийн биржийн түүхэн дэх хамгийн өндөр дүнтэй IPO-нуудын нэг болов.

## “ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН”-ИЙН НЭМЭЛТ ХУВЬЦААНЫ АРИЛЖАА АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА



Канад Улсын Торонтогийн хөрөнгийн бирж болон Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч компани болох “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” нь нийт 17,484,662 ширхэг хувьцааг нэмж гаргах замаар 14,249,999,530 төгрөгийн санхүүжилтийг олон нийтээс татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн арилжааг 2021 оны 10 дугаар сарын 4-ны өдрөөс 10 дугаар сарын 8-ны өдрүүдэд зохион байгуулан тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд 1861 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийт 25,570,677 ширхэг буюу 20,840,101,755 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 1861 захиалга ирүүлсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 46.2 хувиар давсан дүн боллоо.

Андеррайтераас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын 13,041,306 ширхэг буюу 10,628,664,390 төгрөгийн үнийн дүн захиалгыг 100% биелүүлж, олон нийтээс ирүүлсэн нийт 4,443,356 ширхэг буюу 3,621,335,140 төгрөгийн үнийн дүн захиалгыг 35.5%-иар хувь тэнцүүлэн нийлүүлэлтийг хийсэн.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

### “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ” ХОС ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭНД ХАМГИЙН ОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ОРОЛЦСОН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА



Монголын хөрөнгийн биржид нэгж эрхээ бүртгүүлсэн хоёрдох хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох “Мандал ирээдүйн өсөлт” хөрөнгө оруулалтын сангийн гаргасан нэгж эрхийн 95 хувь буюу олон нийтэд санал болгосон 47.5 сая ширхэг нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөс 8 дугаар сарын 5-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Сангийн санал болгосон нэгж эрхийн анхдагч зах зээлийн нийт захиалгыг ҮЦТХТ дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй нийцүүлэхэд 6910 хувь хүн, аж ахуйн нэгжийн нийт 7014 захиалга буюу 47.5 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн олон хөрөнгө оруулагчид оролцсон анхдагч зах зээлийн арилжаа боллоо.

**MANDAL  
ASSET  
MANAGEMENT**

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

₮5.9 их наяд	өсөлт	+97%	+2.9 их наяд
-----------------	-------	------	-----------------

### ТОП-20 ИНДЕКС

44,411 нэгж	өсөлт	+130%	+25,125 нэгж
----------------	-------	-------	-----------------

### MSE A

15,482 нэгж	өсөлт	+70%	+6,412 нэгж
----------------	-------	------	----------------

### MSE B

12,202 нэгж	өсөлт	+63%	+4,724 нэгж
----------------	-------	------	----------------



# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2021 оны 12 сарын 31-ний байдлаар 179 ХК бүртгэлтэй байгаагаас 9.5% буюу 17 ХК нь 100 хувь төрийн өмчит, 5% буюу 9 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 85.5% буюу 153 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна.


Бүртгэлттэй үнэт цаасны хувьд нийт 16.5 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 23.8% буюу 3.9 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 76.2% буюу 12.6 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

Геологи	5
Уул уурхай	11
Хүнд үйлдвэрлэл	3
Ойн аж ахуй	2
Хөдөө аж ахуй	18
Хүнсний үйлдвэрлэл	16
Хөнгөн үйлдвэрлэл	11
Барилгын материал үйлдвэрлэл	12
Барилга, зам угсралт	14
Тээвэр	9
Нийтийн хангамж	16
Худалдаа	16
Үйлчилгээ	9
Хэвлэл мэдээлэл	1
Харилцаа холбоо	1
Санхүү	20
Үл хөдлөх хөрөнгө	12
Технологи	3

## ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДИКАТОРУУД

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжаалагдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 5.97 их наяд төгрөг болж 30 жилийн түүхэн дээд хэмжээнд хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.9 тэрбум төгрөгөөр буюу 97 хувиар өссөн үзүүлэлтэй гарчээ.


### ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /сая төгрөг/



(2021.12.31 байдлаар)

12-р сарын 31-ний байдлаар ТОП-20 индекс 44,411 нэгж хүрсэн бөгөөд энэ нь 2020 оны мөн үетэй харьцуулахад 25,125 нэгжээр буюу 130% хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### ТОП ИНДЕКС 20



(2021.12.31 байдлаар)

Мөн тайлант хугацаанд MSE A индекс 15,482 нэгж хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 6,412 нэгжээр буюу 70%-ийн өсөлттэй байгаа бол MSE B индекс 12,202 нэгжид хүрч энэ нь мөн өмнөх онтой харьцуулахад 4,724 нэгжээр буюу 63%-иар өссөн үзүүлэлттэй байна.


## ТОП-20 ИНДЕКСИЙН САГС

Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журмын дагуу үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн сагсыг 2021 онд дараах компаниуд бүрдүүлж байв.

	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР
1	APU	АПУ ХК
2	AARD	Ард Санхүүгийн Нэгдэл ХК
3	GOV	Говь ХК
4	ERDN	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК
5	INV	Инвескор ББСБ ХК
6	TTL	Таван Толгой ХК
7	TUM	Түмэн Шувуут ХК
8	ADB	Ард Кредит ББСБ ХК
9	MNDL	Мандал Даатгал ХК
10	UID	Улсын Их Дэлгүүр ХК
11	AIC	Ард Даатгал ХК
12	SUU	Сүү ХК
13	MFC	Монос Хүнс ХК
14	MNP	Монгол Шуудан ХК
15	LEND	ЛэндМн ББСБ ХК
16	BODI	Бодь Даатгал ХК
17	NEH	Дархан Нэхий ХК
18	MMX	Мах Импекс ХК
19	BDS	Би Ди Сек ХК
20	ADU	Хөвсгөл Алтан Дуулга ХК

## ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2021 онд нийт 248 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 146 ХК-ийн 733,3 сая ширхэг хувьцааг 304,9 тэрбум төгрөгөөр 10.6 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 4.23 тэрбум төгрөгөөр, 75.8 сая ширхэг нэгж эрхийг 56.8 тэрбум төгрөгөөр, 9.4 сая ширхэг компанийн бондыг 1,414.2 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.




Нийт арилжааны үнийн дүнгийн 21.56 хувийг хувьцааны арилжаа, 0.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 4 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 74.12 хувийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 5.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 3.3 сая ширхэг үнэт цаас арилжигдсан бөгөөд нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.6 дахин өссөн байна.

## ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт 248 удаагийн 146 компанийн 733.3 сая ширхэг хувьцааг 304.93 тэрбум төгрөгөөр арилжсан ба 24.50 хувь буюу 74.69 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 75.50 хувь буюу 230.23 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна.



## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд хувьцааны анхдагч зах зээлд нийт 167.94 сая ширхэг буюу 74.69 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай арилжсан ба энэ нь нийт хувьцааны арилжааны 24.5 хувийг эзэлж байна.

## ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 230.24 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 565.3 сая ширхэг хувьцаа арилжсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 дахин өссөн байна. Нийт 146 ХК-ийн үнэт цаас арилжигдсанаас 92 компанийн үнэт цаасны ханш өсч, 46 компанийн үнэт цаасны ханш буурч, 8 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 69.11 хувь буюу 159.1 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 30.89 хувь буюу 71.12 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа тус тус эзэлж байна.



## ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Тайлант хугацаанд “Инвекор актив ТЗК” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан 2 жилийн хугацаатай, жилийн 14.4 хувийн хүүтэй, нэг бүр нь 400,000 төгрөгийн үнэтэй, нийт 10,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд 4.0 тэрбум төгрөгөөр амжилттай арилжлаа. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлд 0.23 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Тайлант хугацаанд “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Мандал ирээдүйн өсөлт” ХХХОС анхдагч зах зээлийн арилжаагаар 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, арван жилийн хугацаатай, 47.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 47.5 сая ширхэг нэгж эрхийг олон нийтэд амжилттай арилжлаа. Хоёрдогч зах зээлд нийт 28.28 Хоёрдогч зах зээлд нийт 28.28 сая ширхэг, 9.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг арилжсан байна.

## БАГЦЫН АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт 21 хувьцаат компанийн 156.4 сая ширхэг буюу 71.12 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 30.89 хувийг эзэлж байна. Үүнд өндөр дүнгээр арилжаалагдсан эхний гурван хувьцаат компани нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК, “Ард Даатгал” ХК, “АПУ” ХК байна.

## КОМПАНИЙН БОНД

Тайлант хугацаанд бондын анхдагч зах зээлд нийт 6.23 сая ширхэг, 720 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бондыг амжилттай арилжсан. Үүнд:

- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, жилийн 10 хувийн хүүтэй, 2-3 жилийн хугацаатай нийт 5.4 сая ширхэг төгрөгийн бондыг 543.42 тэрбум төгрөгөөр, нэг бүр нь 100 ам.долларын үнэтэй, жилийн 5.8-6.8 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай нийт 523.3 мянган ширхэг ам.долларын бондыг 149.1 тэрбум төгрөгөөр тус тус олон нийтэд санал болгож, нийт 5.95 сая ширхэг, 692.55 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бондыг амжилттай арилжсан.
- “Инвекор ББСБ” ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, жилийн 13 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай 200 мянган ширхэг “Инвекор бонд”-ыг нийт 20 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд арилжсан байна.
- “ЛэндМН ББСБ” ХК-ийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай, жилийн 13-14 хувийн хүүтэй, 75 мянган ширхэг, нийт 7.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий “Лэндбонд” анхдагч зах зээлд амжилттай тус тус арилжигдсан байна.

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 3.2 сая ширхэг бондыг 328.1 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

## БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар I ангилалд 22, II ангилалд 41, III ангилалд 115 хувьцаат компани багтаж байна.

## ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ҮНЭТ ЦААС

	ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ /сая/	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН /тэрбум/
1	Мандал Даатгал	111.44	Ард Санхүүгийн Нэгдэл	86.36
2	Ард Кредит ББСБ	106.64	Мик Холдинг	24.87
3	ЛэндМн ББСБ	65.59	Ард Кредит ББСБ	19.64
4	Бодь Даатгал	39.57	АПУ	17.77
5	Дархан Нэхий	30.27	Ард Даатгал	11.31
6	Мерекс	28.04	Мандал Даатгал	8.72
7	Монос Хүнс	27.04	Тэнгэрлиг Медиа Групп	7.61
8	Түмэн Шувуут	24.76	Түмэн Шувуут	7.04
9	Говь	20.46	Говь	5.62
10	АПУ	15.11	Бодь Даатгал	5.09
11	Жидакс	13.67	Инвескор ББС	5.00
12	Ард Санхүүгийн Нэгдэл	11.70	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн	3.36
13	Ард Даатгал	9.41	Булган Ундрага	2.93
14	Хай Би Ойл	8.69	ЛэндМн ББСБ	2.71
15	Сэнтрал Экспресс Си Ви Эс	7.43	Улсын Их Дэлгүүр	2.16
16	Ремикон	6.38	Монос Хүнс	2.15
17	Айтүүлс	5.12	Мах импекс	1.86
18	Сүү	4.00	Сэнтрал Экспресс Си Ви Эс	1.56
19	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн	3.63	Таван Толгой	1.37
20	Эрдэнэс Сольюшинс	3.59	Би Ди Сек	1.36
21	Монгол Базальт	2.79	Шивээ Овоо	1.28
22	Мик Холдинг	2.07	Сүү	1.22
23	Инвескор ББС	1.75	Монгол Шуудан	1.08
24	Э-Транс Ложистикс	1.75	Жидакс	1.03
25	Женко Тур Бюро	1.55	Шарын Гол	0.85
26	Тандэм Инвэст ББСБ	1.35	Дархан Нэхий	0.66
27	Би Ди Сек	1.19	Мерекс	0.60
28	Тэнгэрлиг Медиа Групп	1.16	Монгол Базальт	0.50
29	Шарын Гол	1.16	Айтүүлс	0.50
30	Хөх Ган	1.15	Баянгол Зочид буудал	0.38

## ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 20 ҮНЭТ ЦААС

ҮНЭТ ЦААС	2020.12.31	2021.12.31	ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ	
			НЭГЖ	ХУВЬ
1 Булган Ундрага	760.80	164,900.00	164,139.20	21,574.55
2 Тэнгэрлиг Медиа Групп	1,954.00	20,000.00	18,046.00	923.54
3 Өндөрхаан	1,200.00	10,100.00	8,900.00	741.67
4 Ард Санхүүгийн Нэгдэл	1,758.00	9,785.00	8,027.00	456.60
5 Түмэн Шувуут	168.98	676.13	507.15	300.12
6 Авто Импекс	1,085.00	4,000.00	2,915.00	268.66
7 Хөвсгөл Хүнс	1,000.00	3,400.00	2,400.00	240.00
8 Хөвсгөл Усан Зам	494.00	1,679.00	1,185.00	239.88
9 Мандал Говь Импекс	135.00	450.00	315.00	233.33
10 Мон-Ит Булигаар	5,000.00	16,200.00	11,200.00	224.00
11 Алтайн Зам	55,000.00	170,000.00	115,000.00	209.09
12 Улсын Их Дэлгүүр	1,230.00	3,781.00	2,551.00	207.40
13 АПУ	605.15	1,804.00	1,198.85	198.11
14 Сүү	205.00	591.40	386.40	188.49
15 Ард Кредит ББСБ	82.10	219.93	137.83	167.88
16 Монноос	1,900.00	4,850.00	2,950.00	155.26
17 Хэрлэн Хивс	48.00	120.00	72.00	150.00
18 Эрчим Баян Өлгий	1,000.00	2,379.00	1,379.00	137.90
19 Монгол Шевро	1,126.00	2,560.00	1,434.00	127.35
20 Монгол Шитгээн	210.08	445.00	234.92	111.82

**ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 20 ҮНЭТ ЦААС**

	ҮНЭТ ЦААС	2020.12.31	2021.12.31	ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ	
				НЭГЖ	ХУВЬ
1	Глобал Монголиа Холдинг	2,000.00	510.00	-1,490.00	-74.50
2	Тав	19,000.00	6,800.00	-12,200.00	-64.21
3	Түшиг Уул	940.00	480.00	-460.00	-48.94
4	Хархорин	1,740.00	1,025.00	-715.00	-41.09
5	Женко тур Бюро	89.00	56.07	-32.93	-37.00
6	Оллоо	34.80	23.00	-11.80	-33.91
7	Хай Би Ойл	60.00	40.23	-19.77	-32.95
8	Дархан Хүнс	3,500.00	2,500.00	-1,000.00	-28.57
9	Монгео	17,000.00	12,400.00	-4,600.00	-27.06
10	Мерекс	28.48	21.00	-7.48	-26.26
11	Хасу Мандал	7,990.00	6,000.00	-1,990.00	-24.91
12	Адуун Чулуун	999.76	755.17	-244.59	-24.46
13	Жуулчин Говь	10,400.00	8,000.00	-2,400.00	-23.08
14	Ар Баянхангай	640.00	500.00	-140.00	-21.88
15	Мүдикс	6,900.00	5,500.00	-1,400.00	-20.29
16	Тээвэр Дархан	9,880.00	8,000.00	-1,880.00	-19.03
17	Шарын Гол	884.17	718.80	-165.37	-18.70
18	Азык	2,560.00	2,150.00	-410.00	-16.02
19	Мон Наб	5,175.00	4,400.00	-775.00	-14.98
20	Хөвсгөл Алтан Дуулга	639.98	551.00	-88.98	-13.90

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# 2021



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ





## АУДИТЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/574

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.АЛТАЙ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 5,520.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,782.1 сая төгрөг буюу 101.5 хувиар давсан нь тайлант онд үнэт цаасны арилжааны дүн өмнөх онуудаас огцом өсч 1.4 их наяд төгрөгт хүрсэн, бүтээгдэхүүний нэр төрөл 9-р нэмэгдсэн зэрэг компанийн үйл ажиллагааны өсөлт, банкны хадгаламжийн хүү буурснаар хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх иргэдийн сонирхол нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны орлогыг 2,738.8 сая, зардлыг 2,719.7 сая төгрөг байхаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 5,520.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,168.2 сая төгрөгийн зардал гарч 3,352.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орлого төлөвлөгөөнөөс 2,782.1 сая төгрөг буюу 101.6 хувиар давж биелсэн байна.

#### **Бусад мэдээлэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын жилийн тайланд 3 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Бусад мэдээлэл нь байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл тухайлбал, биржийн голлох үзүүлэлтийн өөрчлөлт, зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны арилжаа, Top 20 индекс, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, үнэт цаасны данстай иргэдийн тоо, өдөрт арилжаанд оролцогчдын тоо, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэх мэт санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/47/НА-СТА-ТӨА



Упаанбаатар хот  
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Энхдалай

Утас: 261885 Цахим хаяг: enkhdaiaie@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Чанцалдулам

Утас: 261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Аккаунт траст аудит ХХК  
Захирал П.Наранцэцэг

Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (төгрөг)

(2021.12.31 байдлаар)

МӨРИЙН ДУГААР	ҮЗҮҮҮЛЭЛТ	12/31/2020	12/31/2021
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	554,589,808.41	2,729,363,635.92
1.1.2	Дансны авлага	84,130,892.90	97,240,920.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	18,336.58
1.1.6	Бараа материал	24,945,190.03	26,570,837.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	8,921,754.47	7,666,370.89
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	13,160,000.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>685,747,645.80</b>	<b>2,874,020,101.40</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,210,709,148.46	2,121,771,489.56
1.2.2	Биет бус хөрөнгө	561,871,087.08	382,782,168.52
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,772,580,235.54</b>	<b>2,504,553,658.08</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,458,327,881.34</b>	<b>5,378,573,759.48</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	2,193,451,446.28	926,821,279.76
2.1.1.1	Дансны өглөг	2,122,930,190.07	720,558,353.30
2.1.1.3	Татварын өр	9,541,742.21	206,262,926.45
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,921,103.77	14,247,509.45
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	60,979,514.00	
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,205,372,550.05</b>	<b>941,068,789.20</b>
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,205,372,550.05</b>	<b>941,068,789.20</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - Төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,362,216.67	12,362,216.67
2.3.9.1	Хуримтлагдсан ашиг/ өмнөх үеийн /	(21,298,527,848.23)	(22,336,322,387.40)
2.3.9.2	Хуримтлагдсан ашиг /тайлант үеийн /	(1,037,794,539.17)	3,184,549,638.99
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,252,955,331.29</b>	<b>4,437,504,970.28</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>3,458,327,881.34</b>	<b>5,378,573,759.48</b>

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (төгрөг)**

(2021.12.31 байдлаар)

<b>МӨРИЙН ДУГААР</b>	<b>ҮЗҮҮҮЛЭЛТ</b>	<b>12/31/2020</b>	<b>12/31/2021</b>
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>1,100,104,609.43</b>	<b>5,483,078,582.38</b>
2	Борлуулалтын өртөг		
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>1,100,104,609.43</b>	<b>5,501,624,362.55</b>
4	Хүүгийн орлого	20,003,103.96	19,301,917.80
5	Бусад орлого	4,559,025.45	18,545,780.17
6	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
7	Ерөнхий ба удирдлагын зардал	2,088,545,238.55	2,136,265,973.93
8	Бусад зардал	12,682,920.88	30,363,052.75
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	(59,244,602.02)	57,525.18
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-	(1,619,200.00)
<b>11</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(1,035,806,022.60)</b>	<b>3,352,735,578.87</b>
12	Орлогын татварын зардал	1,988,516.57	168,185,939.88
<b>13</b>	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(1,037,794,539.17)</b>	<b>3,184,549,638.99</b>
<b>14</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(1,037,794,539.17)</b>	<b>3,184,549,638.99</b>
<b>15</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(1,037,794,539.17)</b>	<b>3,184,549,638.99</b>

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (төгрөг)

(2021.12.31 байдлаар)

ҮЗҮҮҮЛЭЛТ	ӨМЧ	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ	ХУРИМТЛАГДСАН АШИГ	НИЙТ ДҮН
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(21,406,988,979.67)	2,182,288,739.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				108,461,131.44	108,461,131.44
<b>Залруулсан үлдэгдэл</b>	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(21,298,527,848.23)	2,290,749,870.46
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>				(1,037,794,539.17)	(1,037,794,539.17)
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(22,336,322,387.40)	1,252,955,331.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(22,336,322,387.40)	1,252,955,331.29
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>				3,184,549,638.99	3,184,549,638.99
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(19,151,772,748.41)	4,437,504,970.28

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (төгрөг)**

(2021.12.31 байдлаар)

МӨРИЙН ДУГААР	ҮЗҮҮҮЛЭЛТ	12/31/2020	12/31/2021
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,194,532,385.39</b>	<b>5,699,769,998.43</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,021,521,426.51	4,951,952,451.43
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,660,101.23	10,896,176.00
	Бусад мөнгөн орлого	168,350,857.65	736,921,371.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,263,061,226.88</b>	<b>3,427,313,725.08</b>
	Ажиллагчдад төлсөн	611,476,433.08	585,159,426.87
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	181,230,650.38	182,327,806.06
	Бараа материал худалдан авахад төлсөн	22,173,545.00	23,291,525.19
	Ашиглалтын зардалд төлсөн	44,480,193.75	46,951,542.21
	<b>Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн</b>	<b>5,564,500.00</b>	<b>8,120,710.00</b>
	Татварын байгууллагад төлсөн	162,774,258.68	348,440,826.15
	<b>Даатгалын төлбөрт төлсөн</b>		<b>0.00</b>
	<b>Бусад мөнгөн зарлага</b>	<b>235,361,646.00</b>	<b>2,233,021,888.60</b>
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(68,528,841.50)</b>	<b>2,272,456,273.35</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,116,938.36</b>	<b>19,301,917.80</b>
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,000,000.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	116,938.36	19,301,917.80
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>331,428,503.5</b>	<b>116,984,363.6</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	331,428,503.50	116,984,363.64
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(330,311,565.14)</b>	<b>(97,682,445.84)</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
4	Валютын ханшийн зөрүү		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(398,840,406.64)</b>	<b>2,174,773,827.51</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>953,430,215.05</b>	<b>554,589,808.41</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>554,589,808.41</b>	<b>2,729,363,635.92</b>





НГГИЙН БИРЖ

---

ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

---



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ

Монголын Хөрөнгийн Бирж

**Хаяг:** Сүхбаатарын талбай-3,  
Улаанбаатар 15160, Монгол улс

**Утас:** (+976)-11-313747

**Факс:** (+976)-11-325170

**Веб хуудас:** [www.mse.mn](http://www.mse.mn)

**И-мэйл:** [info@mse.mn](mailto:info@mse.mn)